

**“ГУТАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023.04.28

Дугаар 01

Улаанбаатар хот

Компанийн 2022 оны үйл ажиллагааны
болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-
нийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн тооллогын комиссын 01/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАТБИЛЭГ

**“ГУТАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023.04.28

Дугаар 02

Улаанбаатар хот

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь хэсэг, 62.1.13 болон 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн тооллогын комиссын 01/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 6 хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

1. Б.Батбилэг
2. Б.Баттөр
3. Б.Батхишиг
4. Ч.Цэцэгмаа
5. Т.Билэгт
6. Ц.Төмөр

2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 3 хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

1. Э.Билгүүн
2. Э.Бат-Эрдэнэ
3. Б.Жаргал

3. Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компаний эрх ашгийг дээдлэн ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАТБИЛЭГ

**“ГУТАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2023.04.28

№03

Улаанбаатар хот

ТҮЗ-ийн төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл болон 2023 оны 04 дүгээр сарын 28- ны өдрийн тооллогын комиссын 01/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн

ТОГТООХ нь:

1. “Гутал” ХК-ийн 2023 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг 1 дүгээр хавсралтын дагуу хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналтай баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАТБИЛЭГ